

ДЭД БАЙР ЭЗЭЛСЭН ЭССЭ

ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАТАЛГАА

*Мөнхбаатар овогтой Бат-Оюун
Нийслэлийн Улсын тэргүүний 84 дүгээр
сургуулийн 10^е ангийн сурагч*

Хаврын зөөлөн бороо шиврэн орж, газар дэлхий ногоорон өнгө засч эх нутагт минь зун цаг иржээ. Хотын гудамжаар зөрөн өнгөрөх залуус, байрныхаа гадаа салхилан суугаа хөгшчүүл, тоглоомын талбай дээр тоглож байгаа хүүхдүүдийг харахад нэг л тайван сайхан. Тийм ээ.

Энэ сайхан цагийг ахмад үе минь бидэнд үлдээгээд явсан. Бид чинь эх оронтой, эх түүхтэй, эх оронч, дайчин эрэлхэг ахмадуудтай залуу үеийхэн. Гэхдээ өөртөө асуулт тавьж хариулахыг зорьлоо. Монголын залуу үеийн төлөөлөл болсон М.Бат-Оюун чиний бодлоор “Эх оронч үзэл гэж юуг хэлэх вэ?” гэсэн асуултыг тавьж, өөртөө хариулт өгөхөөр “Эрэл”-д гарлаа.

Эх орон гэдэг бол бидний гишгэх газар шороо, амьсгалах агаар, уух ус минь гэж би дүгнэв. Энэ бүхнийг өвөг дээдэс, ахмад үеийхэн маань халуун зүрх, шударга үнэнч ариун сэтгэлээр халуун амь бүлээн цусаа урсгасан их тэмцлийнхээ үр дүнд бидэнд үлдээсэн.

Өнгөрсөн зуны амралтаар ах эгч, аав, ээжтэйгээ кино театрт “Байтаг богд” гэдэг уран сайхны кино үзснээр “Эх оронч” сэтгэлгээ миний зүрх сэтгэл, оюун санааг хөтлөх болсон билээ. Эх нутгийнхаа сөөм газрын төлөө тэд эрэлхэг баатарлагаар амь насаа үл хайрлан хойч үеийнхээ төлөө тулалдсан. Үнэндээ би энэ киноноос маш их зүйлийг ойлгосон. Бидний үеийхэн өнгөрсөн түүх, ахмад үеийн баатарлаг гавьяаны талаар хэр мэддэг бол гэж бодсноо нуух юун. Киног үзэж суухдаа хүн бүр эх оронч, эх оронч үзэлтэй байх ёстой гэдгийг мэдэрсэн.

Байтаг богд киноны гол дүр болох жүжигчин Ц.Алдармаагийн тоглосон Буянхишигийн дүрээр төлөөлүүлэн авч үзэхэд, буу зэвсэг бариагүй ч чин сэтгэлдээ эх орноо үгүйлж, эх орныхоо төлөө дайсны гүнд нууц хүнд байдалд ямар их тэвчээр гарган, шударгаар тэмцэж буй нь тагнуулчин хүний ур чадвар, үүрэг ямар онцгой чухал болохыг жүжигчин Тамирын дүрээр харуулснаар ойлгож мэдэж авсан.

Энэ л киноноос ахмад үеийн баатарлаг эх оронч залуусын тухай үзэж, бахархаж, бас уйлж сууснаа нуух юун. Энэхүү киноноос үүдэн түүхийг нягтлахаар ХХЕГ-ын “Монгол Улсын хил хамгаалалтын түүх-II” 2008 онд хэвлэгдсэн номтой хожим танилцсан юм. Энэ номонд өгүүлснээр “...Дайсан 1948 оны 7 дугаар сарын 8-ны өглөө Байтаг богдын Бүдүүнхаргайт голын эхээр улсын хилийг нэвтэрчээ. Дайсныг голын хавцал уруудан 400 метрт ойртон хүчээ задалж, давшилтанд орох үеэр Хаянхярваа “Эцсээ хүртэл тулалдана. Амьд баригдахгүй гэж тушаагаад... тулалдсан” баримтаас үзэхэд, зөвхөн нэг өдрийн тулалдаан биш болохыг уншиж судалсан.

Тэр үеийн ахмадууд маань “Жинхэнэ эх оронч” хүмүүс байж. Тэд эх орны төлөө тулалдсан эрэлхэг хөвгүүд байсан байна. Олон сайхан хөвгүүд эх орон, газар нутаг, тусгаар тогтнолынхоо төлөө амиа өргөсөн түүхийг бид цаг ямагт дурсан, хойч үедээ мэдрүүлэх ёстой. Мөн бид ах дүү Зөвлөлт холбоот улсынхаа эрэлхэг, дайчин охид хөвгүүдийг үеийн үед мартаж өсгүй. Нэгэнтээ “Миний нутгийн газар шороонос бурхан гуйсан ч бүү өг” хэмээн Галданбошигт хааны хэлсэн үгэнд тэд үнэнч байжээ.

2019 оны 5 дугаар сарын 4-ний Бямба гаригт ХХЕГ-тай хамтран Халх голын дайны 80 жилийн ойн хүрээнд болсон “Хилийн зөрчлөөс ялалт хүртэл” хэмээх нэгэн сайхан арга хэмжээнд ангийн багш болон найзуудтайгаа оролцох боломж тохиосон юм. Арга хэмжээний үеэр судлаач доктор Н.Даваадоржтой уулзалт хийж, хилийн түүхийн музей, “Хилийн зөрчлөөс ялалт хүртэл” баримтат кино, ХЦДБЧ-ын уран бүтээлчдийн

тоглолт үзсэн нь мэдлэг олж авахын зэрэгцээ, ахмад үеийн дайчин уламжлалаар бахархаж, эх орон, бидний төлөө амиа алдсан баатарлаг ахмад үеэрээ бахархан дурсаж хайрлах сэтгэл өөрийн эрхгүй төрсөн билээ.

Баримтат кино үзэж суухад “Хойч үе та нарыгаа цахлай шувуу нисэхийг хараг гэж хорьхон насандаа бид хорвоогоос явсан юм шүү” хэмээн хэлсэн үг өөрийн эрхгүй нүдний аяганд нулимс хуруулж, мэгшин чимээгүйхэн уйлахад хүргэсэн зүрх зүссэн үг байсан юм. Тийм ээ. Та бүхэн энэ бүхнийг өгөөгүй бол бид өнөөдөр байхгүй байсан шүү.

Манай улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн нэгд: “...эх орон газар нутаг бүх ард түмний өмч бөгөөд төрийн хамгаалалтанд байна” гэж хуульчилсан байдаг. Гэтэл өнөө үед зарим эрх баригчид өвөг дээдсийн амь насаараа дэнчин тавьж хамгаалсан сөөм газраас уул уулаар нь харийн хүмүүст хэдэн хар зоосны төлөө өгч байгаа явдал бол жинхэнэ “эх орноосоо урвагч” мөн гэж бодмоор.

Өнөөдөр “Эх оронч хүн” гэдгийг би хувьдаа таны сэтгэл, хандлагаас эрж хайна гэж үзэж байна. Энэ нь маш энгийн зүйлээс эхтэй бөгөөд тухайлбал, гудамжинд хог хаяхгүй байх, аливаа хэлбэрийн өмчид эзний ёсоор хандах гэх мэт жирийн амьдралын хэв шинж, ердийн алхмуудаас эхэлнэ.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд “Монгол Улсын иргэн бүрийн үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно” гэж зааснаас үзэхэд бид том зүйлийг холоос хайх хэрэггүй. Эх орондоо хайртай, эх оронч гэж хий хоосон ярихаас илүү өөрийн зөв үйлдэл, зөв хандлага, эерэг сэтгэлгээ, хүн чанар, зөв ёс суртахуунаас эхтэй гэж би эргэн тойрныхондоо хэлмээр байна.

Өнөөгийн өсвөр үеэ харахад гадны дуучид, жүжигчид, харь улс орныг шүтэн бишрэх хандлага байдаг. Гэхдээ бид зөв зүйлийг дэмжиж түүнд суралцах хэрэгтэй. Тухайлбал, Япон улсын ерөнхий боловсролын сургалт нь шинжлэх ухааныг заахаасаа илүү эх оронч япон иргэнийг төлөвшүүлдэг ба зөв хүнийг төлөвшүүлэхээс эх оронч иргэн, эх оронч үзлийг нэн тэргүүнд чухалчилдаг гэсэн зүйлийг сонсож байсан. Хэдэн жилийн өмнө Солонгос улс эдийн засгийн гүн хямралд ороход иргэд нь үнэт эдлэл болох алтан зүүлт, гоёл чимэглэлээ бариад улс эх орноо хөгжүүлэхийн төлөө санаа зорилгоо өвөрлөн очиж байсан гэдэг мэдээг ч сонсож байв.

Эцэст нь Монголын хойч ирээдүйд эн тэргүүнд олгох хүмүүжил, төлөвшил бол яах аргагүй “Эх оронч үзэл”, “Эх оронч иргэн”-ийг боловсролоор нь дамжуулан төлөвшүүлэх явдал юм.

Жишээлбэл: Түүхийн хичээлээр дамжуулан дунд сургуулийн сурагчдад Японы жишгээр эх оронч үзлийг төлөвшүүлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Бага наснаас нь энэ үзэл хүмүүжлийн суурийг зөв тавьж өгвөл “Эх оронч үзэл-Үндэсний аюулгүй байдлын баталгаа”-нд бага ч гэсэн хувь нэмэр оруулж байна гэж дүгнэлээ.

Ашигласан материал:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль
- Монгол Улсын хил хамгаалалтын түүх II. УБ., 2008
- Хилийн зөрчлөөс ялалт хүртэл баримтат кино /ХХЕГ-т 2015 онд хийсэн кино/